

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ
ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААРХ ТАЙЛАН**

2024 сарын 03 сарын 20

Улаанбаатар хот

“Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 тоот хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо нь 2 удаа хуралдаж, гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын жишиг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан.

Улмаар тус хороо нь дээр дундсан үүрэг даалгаврын дагуу гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлт, зарын загварыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн тус өдрийн 02 тоот хурлын тэмдэглэлээр гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, дүнг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах үүрэг авсан. Энэ дагуу гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын зарыг өдөр тутмын сонин болох Зууны мэдээ сонины 2024.02.27-ны өдрийн №038, Өдрийн сонины 2024.02.27-ны өдрийн №037, Өнөөдөр сонины 2024.02.27-ны өдрийн №037, Монголын мэдээ сонины 2024.02.27-ны өдрийн №018, Өглөөний сонины 2024.02.27-ны өдрийн №035 дугаарууд болон “Монгол шуудан” ХК-ийн цахим хуудсанд тус тус нийтэлсэн.

Зарын дагуу нэр дэвшигчдийн материалыг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд энэ хугацаанд 7 нэр дэвшигч (Гэрэлт Тэлмэн, Жанчивдорж Баасандорж, Дамирай Ганболд, Шаалуу Наранбат, Нанзад Хосбаяр, Хатанбаатар Энхманлай, Нямдорж Дугар) материалаа ирүүлсэн.

Хороо нь нэр дэвшигчдийн битүүмжилж ирүүлсэн баримт бичгийг үнэлэх, сонгон шалгаруулах хурлыг 2024 оны 03 сарын 18, 20-ний өдрүүдэд 14:00 цагт компанийн 306 тоот хурлын танхимд зохион байгуулсан. Хуралд хорооны дарга О.Одбаяр, гишүүн Д.Балжинням, Б.Ганбаатар, Ч.Амарбаатар, Д.Балдорж (албан томилолтоор хөдөө орон нутагт ажиллаж байгаа тул цахимаар оролцож саналаа өгсөн) нар оролцлоо.

“Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтад материалаа ирүүлсэн 7 нэр дэвшигчдийн материалтай танилцан, сонгон шалгаруулалтын зард тусгагдсан бүрдүүлэх материал, тавигдах шаардлагын дагуу 5 үе шаттайгаар ирүүлсэн баримт бичгийн бүрдэл, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээний 5 хуудас боловсруулан дүгнэж, ярилцлага хийж сонгон шалгаруулалтыг явуулсан.

Нэр дэвшигчдээс Гэрэлтийн Тэлмэнг “Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтад хамгийн өндөр үнэлгээ авч, боловсрол, ур чадвар, ажлын туршлага зэрэг нь сонгон шалгаруулалтын шаардлага хамгийн сайн хангаж байна гэж дүгнэн “Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшүүлж томилуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлд санал дүгнэлтээ хүргүүлсэн.

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО